



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 286


Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Их хурлын Төрөөс эмийн талаар баримтлах бодлого батлах тухай 2014 оны 57 дугаар тогтоолын 5 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эмийн чанарыг хангах чиглэлээр оролцогч талуудтай 2015-2018 онд хамтран ажиллах төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /О.Баяр/-д даалгасугай.
3. Эмийн чанарыг хангах чиглэлээр оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөөний биелэлтийг эмийн сангуудаас жил бүрийн 12 дугаар сард багтаан авч нэгтгэн, 1 дүгээр сарын 10-ны дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд ирүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
4. Эмийн чанарыг хангах чиглэлээр оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөөний биелэлтийг эм ханган нийлүүлэх байгууллага, үндэсний эмийн үйлдвэрүүдээс жил бүрийн 12 сард багтаан авч, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн дээрх төлөвлөгөөний биелэлттэй нэгтгэн, 1 дүгээр сарын 30-ны дотор Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэст ирүүлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-эрдэнэ/-д даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Ганчимэг/-д үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080978

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 07 сарын 19-дөрийн
286 дугаар тушаалын хавсралт

ЭМИЙН ЧАНАРЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ /2015-2018 он/

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | Гарах үр дүн | Шалгуур үзүүлэлт | Хариуцах байгууллага |
|---|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|--------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------|
| 1 | Эм, хангамжийн байгууллага бүр дотоод хяналтын журмыг батлан мөрдөж хэвших | 2015 | Эмийн чанарт тавих дотоод хяналт сайжирна. | Дотоод хяналтын журмыг батлан мөрдөж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. | Эм хангамжийн байгууллага |
| 2 | Эмийн аюулгүй байдлын мэдээллийн тогтолцоог нэвтрүүлэхэд хамтран ажиллах | 2016-2017 | Чанартай, аюулгүй эм хэрэглэх боломж бүрдэнэ. | Эмийн аюулгүй байдлын мэдээллийн программыг суурилуулж ашиглаж хэвшсэн байна. | ЭМСЯ, ЭМХТ ЭХНБ, эмийн сан |
| 3 | Чанарын шаардлага хангахгүй болон цуврал нь тухайн эмийг дагалдах баримтаас зөрүүтэй эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгдсэн тохиолдолд эргүүлэн татах тогтолцоо бүрдүүлэх | 2015-2018 | Иргэдийг чанаргүй бүтээгдэхүүн хэрэглэх эрсдэлээс сэргийлнэ. | Чанарын шаардлага хангахгүй болон цуврал нь тухайн эмийг дагалдах баримтаас зөрүүтэй эм нийлүүлэгдсэн тохиолдолд эргүүлэн татаж, холбогдох арга хэмжээг авсан байна. | Эм хангамжийн байгууллага, МХЕГ |
| 4 | Эх орны эмийн үйлдвэрүүд өөрийн үйлдвэрлэсэн эмийн шинжилгээний сертификатыг цуврал бүрд гаргаж, эм нийлүүлсэн байгууллагуудад өгч хэвших | 2015-2018 | Чанартай хэрэглэх боломжтой болно. | Эмийн шинжилгээний сертификатыг цуврал бүрд гаргаж, эм нийлүүлсэн байгууллагуудад өгсөн байна. | Эмийн үйлдвэр |

| | | | | | | |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|-----------------------------------------------------|-----------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------|
| 5 | Эмийн хүчинтэй хугацаа, хадгалах нөхцлийг стандартын дагуу тогтоох | 2015-2018 | Эмийн нөхцөл, хугацааг тогтооно. | Эмийн хадгалах хүчинтэй үнэн зөв тогтооно. | Эмийн идэвхит бодис ба тогтвортой чанарын судалгаанд тавих ерөнхий шаардлага MNS 6439:2014 стандартын дагуу тогтоосон байна. | Эмийн үйлдвэр |
| 6 | Эмийг хадгалалтын горимын дагуу зөв хадгалах нөхцлийг бүрдүүлэх | 2016 | Эмийн алдагдахгүй нөхцөл бүрдэнэ. | Эмийн чанар байх нөхцөл бүрдэнэ. | Эмийг хадгалалтын горимын дагуу хадгалах нөхцөл бүрдсэн байна. | Эм хангамжийн байгууллага |
| 7 | Эмийн чанарыг алдагдуулахгүйгээр тээвэрлэх нөхцлийг бүрдүүлэх | 2015-2016 | Эмийг зөв тээвэрлэх нөхцөл бүрдэнэ. | Эмийг зөв тээвэрлэх нөхцөл бүрдэнэ. | Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага MNS 5530:2014 стандартад заасан шаардлагуудыг хангасан байна. | Эм хангамжийн байгууллагууд |
| 8 | Эмийг хүлээж авах, түгээхэд бар кодыг нэвтрүүлэх | 2016-2017 | Хуурамч, стандартын бус эм нэвтрэхээс сэргийлнэ. | Хуурамч, стандартын бус эм нэвтрэхээс сэргийлнэ. | Эмийг хүлээж авах, түгээхэд бар кодыг нэвтрүүлсэн байна. | Эм хангамжийн байгууллага |
| 9 | Нэг төрлийн эмийн тун тус бүрийг ялгагдахуйц савлалттай болгох | 2015-2016 | Эмийн тунг андуурч хэрэглэх эрсдэлээс сэргийлнэ. | Эмийн тунг андуурч хэрэглэх эрсдэлээс сэргийлнэ. | Үйлдвэр бүр нэг төрлийн эмийн тун тус бүрийг ялгагдахуйц савлалттай болгосон байна. | Эмийн үйлдвэр, ЭМХТ |
| 10 | Эмийн сангийн дотоод бэлдмэлийн чанарыг сайжруулах | 2015-2016 | Иргэд чанартай эм хэрэглэх нөхцөл бүрдэнэ. | Иргэд чанартай эм хэрэглэх нөхцөл бүрдэнэ. | Найруулан бэлтгэсэн эмийн цуврал бүрийн чанарыг шалгаж бүртгэл хөтөлсөн байна. | Эмийн сан |
| 11 | Шаардлага хангаагүй эмийн шинжилгээний үр дүнд дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагад мэдээлэл хүргүүлэх | 2015-2018 | Шаардлага хангаагүй эмийн эзлэх хувь буурсан байна. | Шаардлага хангаагүй эмийн эзлэх хувь буурсан байна. | Мэдээллийг хагас, бүтэн жилээр гаргаж МХЕГ, ЭМСЯ-д хүргүүлсэн байна. | МХЕГ-ын ХАБУЛЛ |
| 12 | Эмийн хяналтын лабораторийн зохистой дадлын стандартыг боловсруулах | 2016 | Эмийн чанарт тавих хяналт сайжирна. | Эмийн чанарт тавих хяналт сайжирна. | Стандартыг боловсруулж батлуулсан байна. | ЭМСЯ, МХЕГ-ын ХАБУЛЛ, мэргэжлийн холбоо |

| | | | | | |
|----|----------------------------------------------------------------------------------------------|-----------|------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------|
| 13 | Эмийн хяналтын лабораторитой холбоотой ДЭМБ-ын удирдамжуудыг орчуулан, гарын авлага гаргах | 2017 | Эмийн хяналтын лабораторийн үйл ажиллагаа сайжирна. | Гарын авлага хэвлэгдэн гарсан байна. | ЭМСЯ, ДЭМБ, ХАБҮЛЛ-ийн Эмийн хяналтын лаборатори |
| 14 | Эмийн үйлдвэрүүдийн хяналтын лабораторийн хүчин чадлыг сайжруулах | 2016-2018 | Үйлдвэрлэсэн эмийн чанарыг баталгаа-жуулах боломж бүрдэнэ. | Үйлдвэрлэсэн эмийн чанарын шинжилгээг бүрэн хийдэг болно. | Эмийн үйлдвэр |
| 15 | Эмийн хяналтын лабораторийн шинжлэгч нарын чадавхийг сайжруулах сургалт зохион байгуулах | 2015-2018 | Эм шинжлэгч нарын мэдлэг, чадавхи дээшилсэн байна. | Сургалтыг жил бүр зохион байгуулсан байна. | ЭМСЯ, Эм зүй-био анагаахын сургууль, ХАБҮЛЛ-ийн Эмийн хяналтын лаборатори |
| 16 | Эмийн шаардлагатай урвалж бодисоор хангах | 2015-2016 | Эмийн чанар сайжирна. | Эмийн чанарыг бүрэн шинжилж бүртгэл хөтөлсөн байна. | Эмийн үйлдвэр, эмийн сан |
| 17 | Үйлдвэрлэсэн эмийн шинжилгээний үнэн бодит байдлын баталгаажилтыг хийж хэвших | 2015-2016 | Эмийн чанарт тавих хяналт сайжирна. | Эмийн шинжилгээний үнэн бодит байдлын баталгаажилтыг хийж хэвшсэн байна. | Эмийн үйлдвэр |
| 18 | Эрсдэлд суурилсан эмийн хяналтанд чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх | 2016-2017 | Хяналт шалгалтын үр дүн сайжирч, олон улсын төвшинд хүрэх боломж бүрдэнэ. | Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн байна. | ЭМСЯ, ДЭМБ, АХБ, МХЕГ |
| 19 | Хуурамч болон улсын бүртгэлд бүртгэгдээгүй эмийн мэдээлэл солилцох үйл ажиллагааг сайжруулах | 2016 | Зах зээлд хуурамч болон улсын бүртгэлд бүртгэгдээгүй эм тархахаас сэргийлнэ. | Эрх зүйн орчин бүрдсэн байна. | ЭМСЯ, МХЕГ, ГЕГ, ЦЕГ, мэргэжлийн холбоо, эм хангамжийн байгууллагууд |

| | | | | | |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|-----------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------|
| 20 | Эмийн хадгалалт, түгээлт, лабораторийн зохистой дадлын талаар сургалт зохион байгуулах | 2015, 2017 | Эмийг хадгалах, түгээх ажиллагаанд оролцогч талуудын мэдлэг дээшилнэ. | Сургалт зохион байгуулсан байна. | ЭМСЯ, мэргэжлийн холбоо, Эм зүй-био анагаахын сургууль, ХАБУЛП |
| 21 | Эмийн чанар, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтарсан сургалт зохион байгуулах | 2015-2018 | Эмийн мэргэжилтэнүүдийн мэдлэг дээшилсэн байна. | Сургалт зохион байгуулсан байна. | ЭМСЯ, мэргэжлийн холбоо, Эм зүй-био анагаахын сургууль |
| 22 | Клиник эм зүйчдийн эмийн чанар, аюулгүй байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх | 2016-2018 | Клиник эм зүйн тусламж үйлчилгээ сайжирна. | Клиник эм зүйчид сургалтанд хамрагдсан байна. | ЭМХТ, эмнэлгийн эмийн сан |
| 23 | Үндэсний эмийн үйлдвэрүүдийн дунд харилцан туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах | 2016-2018 | Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагаа сайжирна. | Дэвшилтэт технологи, тушрлагыг нэвтрүүлсэн байна. | Эм хангамжийн байгууллагууд |
| 24 | Эмийн чанарын асудлаар семинар, үзэсгэлэн зохион байгуулах | 2016-2018 | Эмийн чанар сайжирна. | Үзэсгэлэн, семинар зохион байгуулсан байна. | ЭМСЯ, ЭМХТ, мэргэжлийн холбоо |
| 25 | Эм зүйн тусламж үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах, эмчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангаж ажиллах | 2015-2018 | Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар сайжирна. | Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангаж ажилласан байна. | Төв, тусгай мэргэжлийн эмнэлэг, МХЕГ, ЭМХТ |
| 26 | Эм зүйн тусламж үйлчилгээний зохистой дадлын стандартуудын мөрдөлтийг хянах | 2015-2018 | Эм зүйн тусламж үйлчилгээ сайжирна. | Стандартын мөрдөлтийг хянасан байна. | Төв, тусгай мэргэжлийн эмнэлэг, МХЕГ, ЭМХТ |